



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/20

Мөрөн сум

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/107 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлттэй холбогдуулан Хөвсгөл аймгийн Тариалан сум, Булган аймгийн Хутаг-Өндөр сум хоорондын хилийн цэсийн орчимд үүссэн маргааныг чиг үүрэг бүхий судалж танилцуулах, санал боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Хуягбаатар (Аймгийн Засаг даргын орлогч)

Б.Ганзориг (Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга)

Гишүүд:

Х.Эгиймаа (Тариалан сумын Засаг дарга)

Д.Энхтөр (Тариалан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга)

О.Бат-Эрдэнэ (Тариалан сумын Газрын даамал)

Б.Жамбалдорж (Тариалан сумын “Таван толгой” багийн Засаг дарга)

Нарийн бичиг:

Э.Дэлгэрмөрөн (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын, Газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)

2.Үүссэн холбогдох хууль тогтоомжийн хүрээнд судалж, танилцуулан авч хэрэгжүүлэх саналыг боловсруулан 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн дотор танилцуулахыг ажлыг хэсгийн ахлагч (Б.Хуягбаатар)-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



М.ХУЯГБААТАР

Захирамж-2023

6717010039